

ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРЫН ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ:

Оюутолгой төслийн хөрөнгө оруулалтын гэрээний 4 дүгээр бүлгийн 4.1-4.4 дэх заалтууд

МОНИТОРИНГИЙН ТУХАЙ

Хил хязгааргүй алхам ТББ нь Нээлттэй Нийгэм Форумын санхүү болон арга зүйн дэмжлэгтэйгээр 2015-2016 онд Оюу толгой төслийн Хөрөнгө оруулалтын гэрээний 4 дүгээр бүлэгт заасан “Өмнийн говийн бүсийн хөгжлийн Зөвлөл” (цаашид ӨГБХЗ гэх), түүний эрх, үүргийн хэрэгжилтэд мониторинг хийлээ. Мониторингийн хүрээнд Хөрөнгө оруулалтын гэрээний 4.1-4.4 дэх заалтын дагуу Засгийн газраас ӨГБХЗ-ийг байгуулж үйл ажиллагааг нь удирдан чиглүүлэх; Зөвлөлийн үйл ажиллагааг олон талын оролцоотой удирдах зөвлөл удирдах; Хөрөнгө оруулагч нь удирдах зөвлөлийн гишүүн байж Зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх; өмнийн говийн бүс нутгийн хөгжлийн стратеги, төлөвлөгөө, төсвийг боловсруулах, санхүүжүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулахад Засгийн газарт дэмжлэг туслалцаа үзүүлэх ӨГБХЗ-ийн үүргийн хэрэгжилтийг тухайлан үнэлэв.

Мониторингийн үр дүнд Хөрөнгө оруулалтын гэрээний талуудын ӨГБХЗ-тэй холбоотой үүргийн хэрэгжилт, түүний үйл ажиллагаанд тулгарч буй бодит саад бэрхшээл, зөрчил дутагдал тэдгээрийн шалтгаан нөхцөлийг тодорхойлж, Зөвлөлийн бүтээлч, үр дүнтэй үйл ажиллагааг нэмэгдүүлэх, улмаар Хөрөнгө оруулалтын гэрээний бүс нутгийн хөгжилд чиглэсэн заалтуудын хэрэгжилтийг хангах талаар тодорхой Зөвлөмж гаргалаа.

Мониторингийн дүгнэлт, зөвлөмжийг Хөрөнгө оруулалтын гэрээний талууд, иргэний нийгмийн байгууллагуудад урьдчилан танилцуулж хэлэлцүүлэг зохион байгуулснаас гадна Эрдэнэс Оюутолгой ХК-д хүргүүлж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд хүргээд байна. Түүнчлэн 2016 онд шинэ Засгийн газар байгуулагдсантай холбоотойгоор ӨГБХЗ нь шинэчлэн байгуулагдах тул мониторингийн дүгнэлт, зөвлөмжийг гэрээний талуудад сайтар танилцуулж, Хөрөнгө оруулалтын гэрээний хэрэгжилт, тэр дундаа ӨГБХЗ-ийн үйл ажиллагааг сайжруулах нөлөөллийн ажлуудыг Хил хязгааргүй алхам ТББ-аас үргэлжлүүлэн хийж байна.

МОНИТОРИНГИЙН ДҮН

Засгийн газраас 2009 онд байгуулсан Оюу толгойн хөрөнгө оруулалтын гэрээ нь тодорхой хугацааны туршид бизнесийн орчныг тогтвортой байлгаж, хөрөнгө оруулагчийг бүтээгдэхүүнээ олон улсын зах зээл дээр борлуулах боломжоор хангах, улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийг хөхиүлэн дэмжих, Монгол Улсын бизнес эрхлэгч компаниуд, хувь хүмүүст бизнесийн шинэ боломж, ажлын байр бий болгохтой холбоотой хөрөнгө оруулагч ба Засгийн газар хоорондын харилцааг зохицуулах зорилготой юм.¹

Бүс нутгийн эдийн засгийг хөгжүүлэх, орон нутагт шинэ ажлын байр бий болгох нь дээрх гэрээний үндсэн зорилгуудын нэг юм. Энэ хүрээнд төсөл хэрэгжиж буй бүс нутагт тогтвортой хөгжлийн бодлогыг тодорхойлж, Засгийн газарт зөвлөн туслах үүрэг бүхий Өмнийн говийн бүсийн хөгжлийн олон талт зөвлөлийг байгуулж, үйл ажиллагааг нь үр дүнтэй удирдан чиглүүлэх үүргийг талууд гэрээгээр хүлээжээ. ӨГБХЗ үр дүнтэй ажилласнаар бүс нутгийн бие даан хөгжих урт хугацааны хөгжлийн бодлогуудын хэрэгжилтийг дэмжиж, Оюу толгой төслийн үр ашгийг нийт ард түмэнд хүртээх нөхцөл бүрдэнэ. Түүнчлэн төслийн нөлөөлөлд өртсөн

¹ http://ot.mn/media/ot/content/about_us/IA/Brochure_About_the_OT_IA_MN.pdf



иргэдэд түлхүү анхаарч нөхөн төлбөр төлөх, байгаль орчны хяналтын хороо байгуулах, өмнийн говийн бүсийн иргэдийг тэргүүн ээлжид ажлын байраар хангах, төсөлд бараа, ажил, үйлчилгээ нийлүүлэх орон нутгийн аж ахуйн нэгжийг дэмжих, цаашид төслөөс бүрэн хамааралгүйгээр хөгжих боломжийг бүрдүүлэх зэрэг асуудлуудыг үе шаттайгаар шийдвэрлэх ач холбогдолтой юм.

2009 онд Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулагдсанаас хойш эрх барьсан аль ч Засгийн газар Хөрөнгө оруулалтын гэрээгээр хүлээсэн бүс нутгийн хөгжлийг дэмжих үүрэг буюу ӨГБХЗ-ийг байгуулж, үр дүнтэй ажиллуулах үүргээ хангалттай биелүүлж ирсэнгүй. 2010 болон 2012 онуудад ӨГБХЗ-ийг байгуулж, Засгийн газрын тогтоол гаргасан боловч зөвлөлийн ажиллах хүрээ, чиг үүрэг, хариуцлага, хяналтыг заалгүй орхигдуулснаас тус зөвлөлийн нэр зөвхөн цаасан дээр үлдэж, ямар ч дорвитой үйл ажиллагаа явуулаагүй өнөөг хүрчээ. Тэр ч бүү хэл Зөвлөлийн зорилго, үйл ажиллагаа нь өмнийн говийн бүсийг бүхэлд нь хамрах уу, эсвэл зөвхөн Өмнөговь аймгийн хэмжээнд байх уу гэдэг талаар талууд харилцан адилгүй ойлголт, байр суурьтай байна. Мониторингийн явцад цуглуулсан мэдээллээс харахад ОТ ХХК тус зөвлөл нь зөвхөн Өмнөговь аймгийн хөгжлийн зөвлөл байх ёстой гэсэн байр суурийг хатуу баримталж байсан бол Засгийн газар энэ талаар ямар нэг тодорхой байр суурь илэрхийлээгүй. Гэхдээ анх 2010 онд “Өмнийн говийн бүсийн хөгжлийн зөвлөл” нэртэйгээр 42 хүний өргөн бүрэлдэхүүнтэй байгуулагдсан зөвлөлийг 2012 онд өөрчлөн байгуулахдаа нэрийг нь “Өмнийн говийн хөгжлийн зөвлөл” болгон өөрчилж, бүрэлдэхүүнийг нь 32 хүн болгож цөөлжээ.

Гэрээ нь талуудын эрх, үүргийг тодорхойлсон эрх зүйн баримт бичиг болохын хувьд заавал биелэгдэх ёстой. Аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлээгүй бол гэрээ болон хуульд заасан хариуцлагыг зохих ёсоор хүлээх учиртай. Өөрөөр хэлбэл, гэрээний тодорхой зүйл заалтын утга агуулгыг талууд өөр өөрийнхөөрөө тайлбарлаж, хэрэгжүүлэхээс хойш суух бус гэрээнд заасан яг тэр агуулгаар нь бүрэн хэрэгжүүлэх ёстой билээ. Бүтэн 5 жилийн хэлэлцээрийн үр дүнд байгуулагдсан Оюу толгойн хөрөнгө оруулалтын гэрээнд бүс нутгийн хөгжил, түүнийг дэмжих бүсийн хөгжлийн зөвлөл гэсэн нэр томъёог санамсаргүйгээр тусгаагүй биз ээ. Хөрөнгө оруулалтын гэрээний 4 дүгээр бүлгийг авч үзвэл бүхэлдээ “Бүс нутгийн хөгжил”-ийг дэмжихэд чиглэжээ. Түүнчлэн гэрээний 4.4-4.5 дахь заалтуудад ӨГБХЗ-ийн үйл ажиллагааны чиглэл болон Хөрөнгө оруулагчийн эрх үүргийг тодорхойлохдоо бүс нутгийн хөгжил болон төсөл хэрэгжиж буй орон нутгийн хөгжил хоёрыг тус тусад нь ялгаатайгаар тодорхойлсон зэргээс харвал Хөрөнгө оруулалтын гэрээний 4 дүгээр бүлэгт заасан зөвлөл нь зөвхөн төсөл хэрэгжиж буй Өмнөговь аймаг бус төслийн нөлөөлөлд өртөж буй өмнийн говийн бүс нутгийг бүхэлд нь хамран ажиллахаар байна. Иймд гэрээний талууд нэн тэргүүнд ӨГБХЗ, түүний хамрах хүрээний талаар нэгдсэн ойлголт, байр сууринд хүрч, Хөрөнгө оруулалтын гэрээнд заасан эрх үүргээ бүрэн дүүрэн хэрэгжүүлэх талаар илүү хүчин чармайлт гарган ажиллах шаардлагатай байна.

Хөрөнгө оруулалтын гэрээний 4-р бүлгийн холбогдох заалт тус бүрийг нарийвчлан авч үзье.

4.1. Засгийн газар нь “Өмнийн говийн бүсийн хөгжлийн Зөвлөл” /цаашид “Зөвлөл” гэх/-ийг байгуулж үйл ажиллагааг нь удирдан чиглүүлнэ.

Оюу толгойн Хөрөнгө оруулалтын гэрээ

- 2009 оноос хойших Засгийн газрууд “Өмнийн говийн бүсийн хөгжлийн зөвлөл”-ийн хамрах хүрээг Хөрөнгө оруулалтын гэрээнд заасан утгаар хэрэгжүүлэлгүй, ялгаатай байр суурь баримталж, өөр өөр нэр томъёо хэрэглэж иржээ. Тухайлбал, Засгийн газрын 2010 оны тогтоолд “Өмнийн говийн бүсийн хөгжлийн зөвлөл” (Southern Gobi Regional Development Council) гэж Хөрөнгө оруулалтын гэрээнд заасан нэр томъёог хэрэглэсэн бол 2012 оны тогтоолд “Өмнийн говийн хөгжлийн зөвлөл” (Southern Gobi Development Council) буюу “бүсийн” гэдэг утгыг орхигдуулжээ. 2008-2012 оны болон 2012-2016 оны Засгийн газрууд ийнхүү тогтоол гаргаж, ӨГБХЗ-ийг байгуулсан боловч гэрээнд заасны дагуу зөвлөлийн үйл ажиллагааг удирдан чиглүүлэх үүргээ огт хэрэгжүүлээгүй байна.
- Засгийн газраас ӨГБХЗ-ийг байгуулахдаа үйл ажиллагаандаа баримтлах дүрэм, журам, чиг үүрэг, хариуцлагыг тодорхойлоогүй. Ялангуяа Хөрөнгө оруулалтын гэрээ, түүний хэрэгжилтийг аль яам, агентлаг хариуцах нь өнөөг хүртэл тодорхойгүй байгаа төдийгүй Эрдэнэс Оюутолгой ХК-ийн цахим хуудсыг эс тооцвол төрийн аль ч байгууллагын цахим хуудсанд Хөрөнгө оруулалтын гэрээг бүрэн эхээр байршуулаагүй байна. Энэ нь Оюу толгойн Хөрөнгө оруулалтын гэрээ, түүний хэрэгжилтэд Засгийн газар маш хайнга



хандаж байгааг харуулж буй. Өөрөөр хэлбэл, гэрээний хэрэгжилтийг ярихад зөвхөн хөрөнгө оруулалт, татвар, орлогын талаас нь харахаас бус орон нутгийн хөгжилд чиглэсэн үүргийн хэрэгжилтэд огт анхаарал хандуулахгүй явж иржээ.

- Хөрөнгө оруулалтын гэрээнд агуулга, утга санаа нь тодорхой заагдсан нэр томъёог ийнхүү санаатай болон санамсаргүй байдлаар өөрчлөн өөр утгаар хэрэглэж байгаа нь Монгол Улсын эрдэс баялгийн салбарт гэрээ байгуулах, түүний хэрэгжилтийг хянах эрх зүйн орчин бүрэн бүрдээгүй байгаатай холбоотой. Мөн тус төслийн удирдлагын багт олон нийтийн эрх ашгийг төлөөлөн Удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүд Хөрөнгө оруулалтын гэрээний орон нутгийн хөгжлийг дэмжих заалтын хэрэгжилтэд төдийлөн анхаарал хандуулахгүй байна. Учир нь уг гэрээ байгуулагдсанаас хойших арав шахам жилд дээрх шийдвэр гаргах түвшний байгууллагын хуралдаануудаар гэрээний дээрх заалтын хэрэгжилтийг хэлэлцсэн эсэх нь тодорхойгүй, гишүүдийн холбоо барих утас, хаяг нь нийтэд нээлттэй бус байна. Түүнчлэн гэрээний хэрэгжилтийг хангахад Эрдэнэс Оюутолгой ХК-ийн оролцоо, чиг үүрэг тодорхойгүй байна.²
- Монгол Улсын эрдэс баялгийн салбарын өнөөгийн бодлого, хөтөлбөр, хууль тогтоомжид бүс нутгийн хөгжлийг дэмжих үүргийг тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд оногдуулсан заалт хомс байна. Харин 2009 онд Оюу толгой төслийн Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулагдсанаас хойш 2014 онд батлагдсан “Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах журам”³, 2009 онд батлагдсан Цөмийн энергийн тухай хуулийн 30 дугаар зүйлд⁴ бүс нутгийн хөгжлийн асуудлыг Хөрөнгө оруулалтын гэрээнд тусгахаар заажээ.

4.2. Засгийн газар, орон нутгийн удирдах байгууллага, Өмнийн говийн бүс нутагт чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагууд, хандивлагч болон олон улсын санхүүгийн байгууллагын төлөөлөгчдөөс бүрдсэн Удирдах зөвлөл Зөвлөлийн үйл ажиллагааг удирдана.

Оюу толгойн Хөрөнгө оруулалтын гэрээ

- ӨГБХЗ-ийн эрх зүйн статус, эрх хэмжээ, чиг үүрэг өнөөг хүртэл тодорхойгүй байна. Засгийн газар байгуулсан учраас түүнд хамаарах нэгж үү?, эсвэл олон талын оролцоо бүхий олон нийтийн байгууллага уу? гэдэг тухай талууд одоог болтол нэгдсэн ойлголтгүй байна. Өнгөрсөн хугацаанд байгуулагдсан ӨГБХЗ-ийн бүрэлдэхүүнийг харьцуулан авч үзвэл: Өмнөговь аймгаас сонгогдсон УИХ-ын 2 гишүүн, Засгийн газрын гишүүд, яам агентлагийн 9 төлөөлөл тус бүр 2 удаа; аймаг, сумдын удирдах ажилтан 13-15, хувийн хэвшлийн 5-6 төлөөлөл тус тус томилогдон ажиллаж байжээ. Харин эрдэм шинжилгээний болон иргэний нийгмийн 8 төлөөлөл байснаа 3 болж буурсан байна. Хөрөнгө оруулалтын гэрээний 4.2-т ӨГБХЗ-ийн бүрэлдэхүүн нь өмнийн говийн бүс нутагт чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгэм, хувийн хэвшил, хандивлагч, олон улсын санхүүгийн байгууллагын төлөөллөөс бүрдэхээр заажээ. Гэтэл Монголын Уул Уурхайн Үндэсний Ассоциациас бусад хувийн хэвшил, иргэний нийгмийн төлөөлөл нь зөвхөн Өмнөговь аймгийн харьяа байгууллагууд байгаа юм. Түүнчлэн 2012 онд байгуулагдсан зөвлөлийн бүрэлдэхүүн дэх иргэний нийгмийн төлөөлөл нь бүгд мэргэжлийн холбоод байгаа нь нийтийн эрх ашгийн төлөө ажилладаг иргэний нийгмийн төлөөллийг хангаж чадахгүй юм. ӨГБХЗ нь 2010 оны сүүл, 2012 оны эхээр нэлээд идэвхтэй ажилласан бол 2012 оны сүүлээс өнөөг хүртэл огт үйл ажиллагаа явуулаагүй, хуралдаан хийгээгүй байна.
- ӨГБХЗ нийт 3 удаа хуралдсан бөгөөд үүнээс хамгийн албан ёсны, үр дүнтэй болсон нь 2010 оны 12 дугаар сарын 6-ны өдөр Улаанбаатар хотноо Гадаад хэргийн яамны

2 “Эрдэнэс Оюу Толгой” ХХК нь төрийн өмчит компани бөгөөд Оюу толгой ХХК-ийн Монголын талын 34 хувийн хувьцааг эзэмшин, “Оюу Толгой” ХХК-ийн үйл ажиллагаанд төрийн оролцоог хэрэгжүүлж ажилладаг.

3 4.1.12 “Хөрөнгө оруулалтын гэрээг бичгээр монгол, англи хэлээр байгуулах бөгөөд хөрөнгө оруулалтын гэрээнд доор дурдсан зүйлийг тусгана. Үүнд: бүс нутгийн хөгжилд оруулах хувь нэмэр.

4 30.1. Энэ хуулийн 15.1.2, 15.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн хөрөнгө оруулагч өөрөө хүсэлт гаргавал үйл ажиллагаа явуулах нөхцөлийг нь тодорхой хугацаанд тогтвортой байлгах зорилгоор түүнтэй хөрөнгө оруулалтын гэрээг 10 хүртэл жилийн хугацаатай байгуулж болох бөгөөд түүнд дараах зүйлийг тусгана: бүс нутгийг хөгжүүлэх, ажлын байр шинээр бий болгох.



дугуй танхимд зохион байгуулагдсан хуралдаан гэж үзэхээр байлаа. Тус хуралдааныг УИХ-ын гишүүн Х.Бадамсүрэн ахалсан бөгөөд УИХ-ын БОХХАА-н байнгын хорооны дарга Д.Балдан-Очир, Төсвийн байнгын хорооны дарга О.Чулуунбат, УИХ-ын гишүүн Х.Наранхүү, ЗТБХБ-ын сайд Ц.Дашдорж, БОАЖ-ын сайд Д.Цогтбаатар болон ЭБЭХЯ, зарим агентлагийн албан тушаалтнууд, Өмнөговь аймгийн удирдлага, тус аймаг дахь Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгч А.Сүхбаатар нар оролцжээ. Уг хуралдаанаар Өмнийн говийн бүсэд буй Оюутолгой, Тавантолгойн бүлэг орд, Нарийн сухайтын төслийг хэрэгжүүлэгч компаниуд өөрсдийн дэд бүтэц болон орон нутгийн хөгжлийг дэмжих хөрөнгө оруулалтын талаар танилцуулга хийснийг Засгийн газрын “Говийн бүсийн дэд бүтцийг хөгжүүлэх хөтөлбөр”⁵, хот төлөвлөлт, экосистемийг хамгаалах төрийн бодлоготой уялдуулах, нэгдсэн зохион байгуулалттайгаар үр дүнтэй хэрэгжүүлэх асуудлыг хэлэлцжээ. Гэхдээ хуралдаанаас ямар нэгэн шийдвэр албан ёсоор гараагүй.

- Тус хуралдаан дээр ЭБЭХ-ний сайд Д.Зоригт “ӨГБХЗ-ийн үйл ажиллагааны дүрмийг 2010 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн 200 тоот тушаалаар баталсан” гэж хэлсэн нь тэмдэглэгдэн үлджээ. Гэвч дээрх тушаал нь Уул уурхайн яамны архивт огт байхгүй буюу тийм тушаал огт гараагүй нь мониторингийн явцад нотлогдсон юм⁶. Мөн ӨГБХЗ-ийн гишүүд ч ийм дүрэм баталсан талаар ямар нэг баталгаа өгөөгүй болно.

4.3. Хөрөнгө оруулагч нь Удирдах Зөвлөлийн гишүүн байх бөгөөд Зөвлөл, түүний үйл ажиллагааг дэмжинэ.

Оюу толгойн Хөрөнгө оруулалтын гэрээ

- ОТ ХХК-иас 2013 онд цахим хуудсандаа байршуулсан⁷ Хөрөнгө оруулалтын гэрээний тухай товч танилцуулгад хөрөнгө оруулагч нь бүс нутгийн хөгжлийг дэмжих талаар “Өмнөговийн бүсийн хөгжлийн зөвлөлийг дэмжин, Өмнөговь аймгийн бизнес эрхлэгчид болон ажилчдад үр шимийг хүртээх үүрэг хүлээнэ” хэмээн бичжээ. Эндээс үзэхэд Хөрөнгө оруулалтын гэрээнд заасан “Өмнийн говийн бүсийн хөгжлийн зөвлөл”-ийн хамрах хүрээг “Өмнөговь аймгийн” хэмээн ойлгож хэрэгжүүлж байгаа нь тодорхой харагдаж байна.
- Хөрөнгө оруулагч тал нь Хөрөнгө оруулалтын гэрээний 4.3-т зааснаар ӨГБХЗ-ийн Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд багтаж, зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үүргээс гадна гэрээний 9.1-д заасны дагуу гэрээгээр хүлээсэн бүх үүргээ биелүүлэх амлалтын хүрээнд гэрээний 4.1-4.4 дэх заалтуудыг бүрэн хэрэгжүүлэх үүрэгтэй билээ. Гэтэл дээрх үүргээ хэрэгжүүлэх талаар бодитой санаачилга гаргаагүй бөгөөд Засгийн газрын аяг харсаар иржээ. Учир нь гэрээний нөгөө тал буюу Засгийн газраас ӨГБХЗ-ийн үйл ажиллагааг удирдан чиглүүлэх үүргээ хэрэгжүүлэхгүй байгааг мэдсээр атлаа. ОТ ХХК гэрээнд заасан эрхийнхээ хүрээнд хүсэлт, мэдэгдэл, шаардлага хүргүүлэх зэргээр бүс нутгийн хөгжилд чиглэсэн гэрээний 4 дүгээр бүлгийн хэрэгжилтийг хангах талаар ямар нэгэн санаачилга гаргасан тухай баримт нотолгоог бидэнд гаргаж өгөөгүй болно. Түүнчлэн ОТ ХХК-ийн удирдлагын багийн хурлаар ӨГБХЗ-ийн асуудлыг огт хэлэлцэж байгаагүйгээс харахад компанийн Удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага ч энэ талаар огт санаачилга гаргаагүй нь харагдаж байна.
- Оюу толгой төслийн менежментийг хэрэгжүүлэгч Рио Тинто групп нь олборлох үйлдвэрлэлийн төсөл хэрэгжүүлэх явцад тухайн бүс нутгийн хөгжлийн асуудлаар төрийн захиргааны төв байгууллагуудын оролцоотой олон талт ажлын хэсэг байгуулж, үр дүнтэй хамтран ажиллаж байсан туршлагыг илтгэн харуулах мэдээлэл мониторингийн явцад бидэнд олдоогүй болно. Харин энэхүү тайлан дүгнэлт гарсны дараа буюу өчигдөрхөн (2016 оны 9 дүгээр сарын 20) зарим нэг мэдээлэл нэмж өгснийг бүрэн судалж энэхүү тайланд оруулаагүй болохыг энд онцлон дурдах нь зүйтэй юм. Харин Рио Тинто групп тухайн төсөл байрших орон нутгийн засаг захиргааны анхан шатны нэгжтэй Хамтын ажиллагааны гэрээ байгуулж, түүндээ харилцааны хороо, хөгжлийн сан үүсгэн удирдаж байсан туршлагатай болох нь Австрали Улсад явагдаж буй төмрийн хүдрийн уурхайн төслийн мэдээллээс харагдаж байна.

5 Үндэсний хөгжил шинэтгэлийн хорооны боловсруулж батлуулсан бодлого

6 ЭБЭХЯ-ны сайдын 2010 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн 200 тоот тушаал нь өөр агуулгатай буюу албан томилолтын талаарх тушаал болохыг тус яамны бичиг хэргээс мэдэгдсэн болно.

7 http://ot.mn/media/ot/content/about_us/IA/Brochure_About_the_OT_IA_MN.pdf



4.4. Зөвлөл нь Өмнийн говийн бүс, орон нутгийн хөгжлийн стратеги, төлөвлөгөө болон төсвийг боловсруулах, санхүүжүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулахад Засгийн газарт дараах чиглэлээр туслалцаа үзүүлнэ:

- 4.4.1. орон нутгийн болон бүсийн хөгжил, ил тод, хариуцлагатай засаглалыг дэмжих;
- 4.4.2. шилжин суурьших хөдөлгөөнийг зохицуулах;
- 4.4.3. хот төлөвлөлт, хот байгуулалт, түүний дотор эрчим хүч, зам харилцаа, усан хангамж, дулаан, бохир усны асуудлыг шийдвэрлэх;
- 4.4.4. албан болон албан бус боловсрол, түүний дотор англи хэлний сургалт, тусгай мэргэжлийн сургалт явуулах;
- 4.4.5. хүн амын эрүүл мэндэд анхаарал хандуулах, оношилгооны төв байгуулах, соёл урлагийн байгууллагууд, биеийн тамир, спортын байгууламжийг барих, мал эмнэлгийн үйлчилгээг сайжруулах;
- 4.4.6. орон нутгийн засаг захиргаа болон иргэний нийгмийн чадавхыг дэмжих.

Оюу толгойн Хөрөнгө оруулалтын гэрээ

- Мониторингийн судалгааны явцад Хөрөнгө оруулалтын гэрээний дөрөвдүгээр бүлгийн 4.4. дэх заалтын хэрэгжилттэй холбогдох мэдээллийг талууд огт гаргаж өгөөгүй бөгөөд ОТ ХХК-ийн орон нутгийн хэлтсээс ирүүлсэн мэдээлэл нь Хөрөнгө оруулалтын гэрээний 4 дүгээр бүлгийн 4.5-4.13 дахь заалтаар хөрөнгө оруулагчийн хүлээсэн үүргийн биелэлтийн тухай мэдээлэл байсан тул энэхүү тайланд ашиглаагүй болно.

МОНИТОРИНГИЙН ҮР ДҮНД ҮНДЭСЛЭСЭН ЗӨВЛӨМЖ

ЗАСГИЙН ГАЗАРТ:

1. Оюу толгой төслийн Хөрөнгө оруулалтын гэрээний 4 дүгээр бүлэгт заасан “Өмнийн говийн бүсийн хөгжлийн зөвлөл”-ийн хамрах хүрээг гэрээнд заасан утга агуулгаар буюу говийн бүсийн хэмжээнд авч үзэж, төрийн албан ёсны баримт бичгүүдэд гэрээний нэр томъёог өөрчлөлгүйгээр нэг мөр хэрэглэдэг болох;
2. ӨГБХЗ-ийг байгуулах тухай Засгийн газрын тогтоолыг шинэчлэхийн өмнө холбогдох бэлтгэлийг сайтар хангаж, ӨГБХЗ-ийн эрх зүйн статус, үйл ажиллагаандаа баримтлах дүрэм, чиг үүргийг Засгийн газрын өргөтгөсөн хуралдаанаар хэлэлцэн батлах, улмаар ӨГБХЗ-ийн үйл ажиллагааг эхлүүлж, улс төрөөс хараат бус ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;
3. Хөрөнгө оруулалтын гэрээнд зааснаар ӨГБХЗ нь Өмнийн говийн бүсийн хөгжлийн асуудлаар Засгийн газарт зөвлөх, дэмжлэг үзүүлэх зорилготой бүтэц учраас Засгийн газар, яамдын төлөөллийг цөөлж, хувийн хэвшил, иргэний нийгмийн төлөөллийг нэмэгдүүлэх, ялангуяа говийн бүсэд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг нийтийн эрх ашгийн төлөөх төрийн бус байгууллага, иргэд, усны сав газрын захиргаад, Дундговь, Дорноговь аймгийн төлөөллийг зөвлөлийн бүрэлдэхүүнд оруулах;
4. Эрдэс баялгийн салбарын эрх зүйн орчин, тэр дундаа хөрөнгө оруулалтын гэрээ байгуулахтай холбоотой хууль эрх зүйн орчныг сайжруулах, хуулиудын хоорондын уялдаа холбоог хангах замаар цаашид Монгол Улсын эрх ашиг, хууль тогтоомжид нийцсэн сайн гэрээ байгуулах, түүний хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах нөхцөлийг бүрдүүлэх;
5. Засгийн газрын 2014 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах журам”⁸-д заасны дагуу Хөрөнгө оруулагчийн жил бүрийн тайланд аудитын дүгнэлт гаргуулж, олон нийтээр хэлэлцүүлж, УИХ-аар хэлэлцдэг байх эрх зүйн орчныг бүрдүүлэх;

- 8 5.1 Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан хөрөнгө оруулагч хуулийн этгээд нь Хөрөнгө оруулалтын тухай хууль болон хөрөнгө оруулалтын гэрээнд заасны дагуу хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа, төслийн хэрэгжилтийн талаарх тайлангаа дараа жилийн 1 дүгээр улиралд багтаан хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гаргаж өгөх үүрэгтэй.
- 5.2 Хөрөнгө оруулалтын гэрээний хэрэгжилтэд хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хяналт тавих бөгөөд шаардлагатай тохиолдолд салбарын болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж болно.



6. Дээр дурдсан “Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах журам”-д гэрээний хэрэгжилтийн тайлан гаргаагүй, эсхүл гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор хэрэгжүүлээгүй талын эсрэг иргэд, иргэний нийгмийн байгууллагууд гомдол, нэхэмжлэл гаргадаг байх зохицуулалтыг нэмж тусгах;
7. Цаашид эрдэс баялгийн салбарт байгуулагдах аливаа гэрээнд баялгийн эзэн болох иргэдийн санал хүсэлтийг тусгах эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай. Тухайлбал, орон нутгийн хөгжил, тэр дундаа хүний хөгжлийг хэрхэн хангах, ямар дэд бүтцийг бий болгох, гэрээний талуудын үүрэг амлалтын биелэлтийг хэрхэн хянах, гомдол нэхэмжлэл гаргах, гэрээний ил тод байдлыг хангах зэрэг асуудлыг иргэдийн оролцоотой шийдвэрлэж, гэрээнд тусгах эрх зүйн орчныг бий болгох нь чухал байна.
8. Захиргааны ерөнхий хууль, Хууль тогтоомжийн тухай болон Нийтийн сонсголын тухай хуулиудыг эрдэс баялгийн салбарт бүрэн хэрэгжүүлэх бүхий л боломжийг дэмжиж, иргэдийн оролцооны эрхийг баталгаажуулах;
9. “Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1.12-т Хөрөнгө оруулалтын гэрээнд бүс нутгийн хөгжлийн асуудлыг тусгахаар заажээ. Иймд цаашид энэ салбарт Засгийн газраас байгуулах гэрээнд тухайн төслийн хувьд бүс нутаг гэдгийг хэрхэн ойлгох талаарх нэр томьёоны тайлбарыг тусгаж байх, ингэхдээ холбогдох аймаг, сум тус бүрийн нэрийг тодорхой зааж оруулдаг байх;
10. ӨГБХЗ-ийн үйл ажиллагааг өмнийн говийн бүсийг бүхэлд нь хамрах байдлаар тодорхой үе шаттайгаар хэрэгжүүлж болох юм. Тухайлбал, эхний ээлжид Өмнөговь аймгийн хэмжээнд, тодорхой хугацааны дараа буюу ӨГБХЗ-ийн үйл ажиллагаа тогтворжсоны дараа говийн бүсийн бусад аймаг, сумдыг хамарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх гэх мэт. Энэ нь Хөрөнгө оруулалтын гэрээний талууд бүс нутгийг хамарсан олон талт зөвлөл байгуулж ажиллах туршлага хомс байгаа өнөөгийн нөхцөлд хамгийн зөв гарц байж болох юм.
11. Дэлхий нийтийн “Тогтвортой хөгжил 2030” зорилтын үзэл баримтлалд нийцүүлэн эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудлыг, ялангуяа нэн эмзэг говийн бүсэд байгаль орчин экологи, уур амьсгалын өөрчлөлтөөс тусад нь авч үзэх боломжгүйг онцгой анхаарч, Өмнийн говийн бүсийн аймгуудыг тогтвортой хөгжлийн нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах шаардлага байгааг анхаарах нь зүйтэй.

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ТАЛ БА ОТ ХХК-Д:

12. Хөрөнгө оруулалтын гэрээний хэрэгжилтийг хангахад ОТ ХХК илүү үүрэг, оролцоотойгоор манлайлж ажиллах ёстой. Хөрөнгө оруулагч тал нь гэрээний 4 дүгээр бүлгийн 4.5-4.13-ын дагуу хүлээсэн үүргээ тодорхой хэмжээнд хэрэгжүүлж байгаа хүчин чармайлтаа хадгалан, улмаар ӨГБХЗ-ийн үр дүнтэй, жигд, тогтвортой үйл ажиллагааг хангахад ОТ ХХК, түүний удирдлагын баг илүү анхаарал хандуулж, санаачилгатай ажиллах;
13. Оюу толгой төслийн Хөрөнгө оруулалтын гэрээний 4 дүгээр бүлгийн “Бүс нутгийн хөгжил” гэсэн ойлголтыг Засгийн газрын 2014 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1.12-т заасан “бүс нутгийн хөгжил” гэсэн ойлголттой адилтган үзэж, цаашид үл маргах, зөрүүтэйгээр тайлбарлах аливаа хандлага, байр суурь гаргахгүй байх;
14. Хөрөнгө оруулалтын гэрээний бүс нутагт чиглэсэн гэрээний үүргийн хэрэгжилтийн тайланг жил бүр гаргаж, ОТ ХХК-ийн удирдлагын багийн хуралдаанаар хэлэлцэн баталж, олон нийтэд нээлттэй болгож, тодруулга тайлбар авах, санал дүгнэлт гаргах, хэлэлцүүлэг өрнүүлэх боломжоор хангах;
15. Оюу толгой төслийн хүрээнд байгуулагдсан аливаа гэрээний хэрэгжилтэд иргэний нийгэм болон бусад байгууллагаас хийж буй мониторинг, хөндлөнгийн хяналт судалгааны ажилд хүндэтгэлтэй хандаж, үнэн зөв, бүрэн мэдээллийг цаг тухай бүр шуурхай гаргаж өгдөг арга барилд суралцаж, өдөр тутмын үйл ажиллагаандаа нэвтрүүлэх;
16. ОТ ХХК-иас олон нийтэд нээлттэй болгохыг зорьсон аливаа мэдээллээ олон нийт, уугуул иргэдэд ойлгомжтой энгийн хэллэгээр боловсруулсны дараа монгол хэлээр, ойлголтын зөрүүгүйгээр орчуулж хүргэхэд анхаарах;
17. Энэхүү мониторингийн дүгнэлт, зөвлөмжийг ОТ ХХК болон Эрдэнэс Оюутолгой ХК-ийн удирдлагын зөвлөл, удирдлагын багийн гишүүдэд танилцуулж, тодорхой шийдвэр гаргаж ажиллах.



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

Жамьян гүний гудамж -5/1,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар - 14240,
Утас: (976-11) 313207
Факс: (976-11) 324857

Энэ дугаарт Хил хязгааргүй алхам ТББ-аас хийсэн Оюутолгой төслийн Хөрөнгө оруулалтын гэрээний 4 дүгээр бүлгийн 4.1 – 4.4 дэх заалтуудын хэрэгжилтэд хийсэн хяналт, мониторингийн үр дүнг хэвлэн нийтэлж байна. Энэхүү мониторинг нь Хил хязгааргүй алхам ТББ-аас ирүүлсэн сэдвийн хүрээнд ННФ-ын санхүүжилт болон арга зүйн дэмжлэгтэйгээр хийгдсэн болно.